



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/151

Чингис хот

Буриад түмний урлаг, спортын
“Алтаргана-2018” бага наадмыг орон нутагтаа
зохион байгуулах хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын “а”, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17 дахь заалт, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 02 дугаар тогтоол, 2017 оны “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх” дэд хөтөлбөр батлах тухай 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.1.3 дахь заалт, хэрэгжүүлэх зорилгоор “Алтаргана-2018” бага наадмыг 5 дугаар сард Дадал суманд зохион байгуулж, наадмын зохион байгуулах хороог нэгдүгээр хавсралтаар, бага наадмын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар, наадмын зардлын төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Бага наадмыг зохион байгуулалтын өндөр түвшинд явуулж, их наадамд оролцох авьяастнуудын мэдүүлгийг удирдамжид заасан хугацааны дагуу үндэсний хороонд хүргүүлэхийг зохион байгуулах хорооны дарга /Г.Лхагвахатан/-д даалгасугай.

3. “Алтаргана-2018” бага наадамд шаардагдах хөрөнгийг “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

